


БАТЛАВ  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



С.БАТБОЛД

## ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ-СҮМБЭР БООМТ ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр

№ ТЭЗҮ-20/24

Улаанбаатар хот

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Дорнод аймгийн Халхгол-Сүмбэр боомт чиглэлд авто зам барихаар төлөвлөн авто замын чиглэлийг тогтоох, нийгэм эдийн засгийн судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын дүгнэлт зэргийг судлах үүднээс энэхүү авто замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах шаардлага гарч байна.

Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлээр авто замын чиг сонголт, авто замын ангиллыг тогтоох, авто зам, замын байгууламжийн ерөнхий төлөвлөлт, хийц, инженерийн байгууламж, уулзвар огтлолцлуудын шийдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үнэлгээ, эдийн засгийн тооцоо, нийгмийн судалгаа зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх юм.

### ХОЁР. ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Уг төслөөр Дорнод аймгийн Халхгол-Сүмбэр боомт чиглэлийн авто замын техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж гүйцэтгэнэ.

Төслийн нутаг дэвсгэрт Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрийн хэсгүүд хамрагдана.

Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаанд инженерийн хайгуул судалгаа, буурь хөрсний инженер-геологийн судалгаа, замын үндсэн материалын судалгаа, трассын дагууд хамрагдаж байгаа түүх, соёлын дурсгалын судалгаа, инженер геодезийн судалгаа, авто замын трассын хувилбарууд болон сонголт, урьдчилсан төлөвлөлт, ажлын тоо хэмжээ, барилга угсралт, засвар арчлалтын ажилд шаардагдах хөрөнгийн тооцоо, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, хөрөнгө оруулалтын үр ашиг, мэдрэмжийн шинжилгээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга зам зэрэг багтана. (Авто зам төсөллөх ЗЗБНБД22-004-2016 нормын 2-8 дугаар хавсралтыг ашиглах)

### ГУРАВ: ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дүгнэлт гаргах, авто замаас болон тээвэрлэлтээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тал дээр онцгой анхаарч төлөвлөлтийг хийх ("Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016 нормын 2-8 дугаар хавсралтыг ашиглах)

- бусад салбаруудад төслийн замаас үзүүлэх нөлөө
  - Нийгмийн хөгжил, улс, орон нутаг, бүс нутгийн төсөв, үнэ тарифт уг төслийн үзүүлэх нөлөө
  - Нийгмийн бусад салбаруудад төслийн замаас үзүүлэх нөлөө
- 2.2 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлага
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн хэтийн судалгаа
  - Хөдөлгөөний эрчмийн шинжилгээ
  - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн өөрчлөлт
  - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн хэтийн өсөлтийн талаарх төсөөлөл
  - Аялал үүсэх, шингэх цэгийн судалгаа
  - Тэнхлэгийн ачааллын судалгаа
  - Стандарт тэнхлэгийн ачааллын тооцоо
- 2.3 Төсөллөж буй авто замын хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ
- Тээвэр ашиглалтын зардал, төсөл хэрэгжсэн үеийн тээвэр ашиглалтын зардлын хэмнэлт
  - Зам хэрэглэгчийн зардал, төсөл хэрэгжсэн үеийн зам хэрэглэгчийн зардлын хэмнэлт
  - Тээврийн хэрэгслийн осол аваарын судалгаа, төсөл хэрэгжсэн үеийн осол аваар бууралтаас гарах хэмнэлт
  - Төслийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өнөөгийн цэвэр үнэ
  - Мэдрэмжийн шинжилгээ
  - Эдийн засгийн ач холбогдол
- 2.4 Төлөвлөж буй авто замын хөрөнгө оруулалтын нийгэм эдийн засгийн үр ашгийн шинжилгээ
- Нийгэм эдийн засгийн судалгаа
  - Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа
  - Ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөөлөл
  - Мэдрэмжийн шинжилгээ
  - Нийгэм эдийн засгийн ач холбогдол

## 2.5 Төслийн хураангуй тайлан.

### 3. Байгаль орчны үнэлгээ

- 3.1 Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
- 3.2 Түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа хамгаалах арга зам
- 3.3 Төслийн авто замаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, урьдчилсан үнэлгээ, зардал
- 3.4 Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө ("Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016 нормын хавсралт 2-ыг ашиглах)

### ЗУРГАА. ОНЦГОЙ НӨХЦӨЛ

1. Хучилтын хийц болон өргөнийг төлөвлөхдөө тухайн чиглэлийн замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал, хөдөлгөөний эрчим, хэтийн өсөлтийг үндэслэл болгон тэнхлэгийн ачаалал, овор хэмжээ зэргийг нарийвчлан тооцох;
2. Төлөвлөж буй авто замын трассыг тогтоохдоо тухайн бүс нутагт баригдсан, одоо баригдаж байгаа авто зам болон цаашид тухайн бүс нутагт баригдахаар төлөвлөж байгаа авто зам, төмөр замтай огтлолцох цэгүүдийг оновчтой тогтоох, холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авах.
3. Хот суурин газраар дайран өнгөрөх хэсгүүдийн аюулгүй нөхцөлийг хангах, хөгжлийн бодлого өрөнхий төлөвлөгөөтэй уялдуулах.